

Хялгасан хуурын хөглөгөө, дарлагын асуудалд

Боржигонмөнхийн Сансар 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ sansaer2408@gmail.com

Хураангуй: Хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсэг болох хорчин цоор, цахар хийл, ойрад икил, морин хуур нь монголчуудын уламжлалт соёлын чухал бэлгэдэл юм. Эдгээр хөгжмийн зэмсгүүд нь тухайн бүс нутгийн газар зүй, соёл, амьдралын хэв маягаас хамааран өвөрмөц онцлогтой хөгжиж ирсэн. Хорчин цоор нь баатарлаг туульсыг дагалдан, цахар хийл нь ордны хөгжмийн “Асар” аялгууны гол хөгжим болсон бол, ойрад икил нь говь нутгийн тэмээ, морины явдлийг дүрсэлсэн аялгуугаараа, морин хуур нь монголчуудын морьтой холбоог илэрхийлсэн хөгжим юм. Энэхүү судалгааны ажил нь хялгасан хууруудын гурван төрлийн хөглөгөө (цоор хөг, цахар хөг, боржигин хөг) ба таван төрлийн дарлагын техник (хуур дарлага, торгууд дарлага, буйллаг дарлага, түүвэр дарлага, ойрад дарлага)-ийг системчлэн судалж, тэдгээрийн соёлын ач холбогдлыг тодорхойлсон. Мөн уг судалгаа нь эдгээр хөгжмийн зэмсгүүдийг хамгаалах, өвлүүлэх, орчин үеийн боловсролд нэвтрүүлэх арга замыг санал болгож байна.

Түлхүүр үгс: язгуур урлаг, хөгжмийн зэмсэг, зэмсэг судлал

Problems about tuning, intonation and playing of string instruments

Sansar Borjigonmunkh 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ sansaer2408@gmail.com

Abstract: The traditional musical instruments such as the Khochin Tsuur, Tsahar Khail, Uriankhai Ikil, and Morin Khuur are important components of Mongolian traditional culture. These musical instruments have evolved with unique characteristics based on the local customs, culture, and lifestyle of their respective regions. The Khochin Tsuur follows the heroic epics, the Tsahar Khail has become a major musical instrument in the “Asar” genre of traditional music, the Uriankhai Ikil represents the life of camels and horses in the steppe through its music, and the Morin Khuur expresses the Mongolian people’s connection with horses. This research systematically studies the three types

of wind instruments (tsuur, khail, and borchigin) and five types of playing techniques (khuur, torghuud, burlag, tuvur, and Uriankhai techniques) and clarifies their cultural significance. Additionally, this study proposes methods for protecting, promoting, and integrating these musical instruments into modern education.

Keywords: *folk art, musical instruments, instrument studies*

Оршил

Хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсэг нь монголчуудын дунд өргөнөөр уламжлагдсан ч өөр өөрийн онцлогтой. Хөгжим судлаач Ж.Энэбиш “Малчны ахуйд өсөж хүмүүжсэн монгол хүний уран сайхны сэтгэлгээ, туурвин бүтээх аргын жинхэнэ утга учрыг тухайн хүнийг төрүүлсэн байгаль, газар зүйн орчин, цаг улирал, малчны өдөр тутмын амьдрал, зан үйл, эрхлэх хөдөлмөрөөс ангид авч үзэхийн аргагүй юм” (Энэбиш 2017, 56) гэсэн байдаг. Хялгасан хуурын үүсэл хөгжил нь ч мөн адилхан учир утгатай. Өвөр монголд уламжлагдаж ирсэн хялгасан хууруудыг доорх хэдэн төрөлд ангилж болдог.

- Урлаж сийлсэн хийц хэлбэрээр нь: морин хуур, арьсан хуур, луу хуур, хүрзэн хуур, матрын толгойтой хуур зэрэг,
- Хөглөж байгаа хөглөгөөгөөр нь: цоор хөг, цахар хөг, луу хөг, хуур хөг, хийл хөг, боржигин хөг, дүүжин хөг, солгой хөг, өрөөлт хөг, жонон хөг гэх мэт,
- Дарлагын талаас нь: түүвэр дарлага, буйллаг дарлага, хуур дарлага, торгууд дарлага, ойрад дарлага,
- Өвлөн уламжлагдаж ирсэн байдлаар нь: Хорчин нутагт уламжлагдаж байгаа хорчин цоор нь эртний үед Мангасын үлгэрт хавсрал хөгжмийн хэлбэртэй хөгжсөөр иржээ. Өнөөгийн нөхцөлд Хорчин нутгийн хагас тариалан, хагас мал аж ахуйтай өв соёлын орчин ахуйгаас болж хорчин цоорын онцлог шинж нь Хорчин нутгийн ардын дуу хөгжмийн хэв намбад шингэсэн байна. Морин хуур нь нийт монголчуудад монгол хүн, монгол морь хоёрын шүтэлцээг үүсгэсэн. Цахар хийлийн хувьд эртний Юань гүрний үеэс эхлэн ордны найрал хөгжмийн ангид Асар аялгууг хөгжимдөж, тулгуур хөгжмийн зэмсэг нь байсан учир ордны хөгжмийн хэв набатай байна. Ойрад иkil нь ойрад урианхайчуудын дунд уламжлагдаж, тэдний амьдралын зан заншил, оршин суугаа орон нутаг болох говь нутгийн онцлогийг агуулж, уламжлалт ая аялгуу нь тэмээ ба морины явдлыг дүрсэлсэн байна.

Энэхүү судалгааны гол зорилго нь:

- Хялгасан хууруудын төрөл, хөглөгөө, дарлагын арга барилыг системчлэн ангилах, тэдгээрийн онцлогийг тодорхойлох
- Хөгжмийн зэмсэг бүрийн хөгжилд нөлөөлсөн газар зүй, соёл, түүхэн хүчин зүйлсийг судлан, тэдгээрийн уламжлалт дуу хөгжмийн холбоог илрүүлэх
- Хялгасан хуурын хөгжимдөлтийг хамгаалах, өвлүүлэх, орчин үеийн хөгжмийн боловсролд нэвтрүүлэх арга замыг санал болгох болно.

Энэхүү судалгаа нь уламжлалт хялгасан хуурын (хорчин цоор, цахар хийл, ойрад икил, морин хуур гэх мэт) хөгжимдөлт, хөглөгөө, дарлагын онцлогийг гүнзгийрүүлэн судлахыг зорьсон. Өвөр монголын хялгасан хуурын олон төрлийн хөглөгөө болон дарлагын талаарх дэлгэрэнгүй судалгаа нэлээд цөөн байна.

1959 онд БНХАУ-ын Бээжин хотноо болсон “Бүх улсын анхдугаар дуу хөгжмийн хурал”-д монголчуудын уламжлалт язгуур урлаг нь олон түмний сонорт хүрч хөгжсөн байна. Мөн алдарт морин хуурч Сандүүрэн, Алтансан нар 1962 онд “Морин хуур ба түүний хөглөгөө, дарлагын тухайд” нэгэн сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл нийтэлж хялгасан хуурын хөглөгөө болон дарлагын нэр томьёог тайлбарлан жигдэлж, хожим хойшдын судалгааны суурь тавигдсан байна. Хялгасан хуурч Бүрэнбаярын нийтэлсэн “Хялгасан хуурын үүсэл хөгжил жич гурван зүйлийн хөглөгөө, таван зүйлийн дарлагын систем” нэг сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл нь өмнөх судалгаанд тулгуурлан хялгасан хуурын хөглөгөө, дарлагын нэр томьёог системчлэн оноосон байна.

Судалгааны одоогийн байдлаар хялгасан хууруудын тухай судалгааны гол хандлага болон үлдсэн асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

- Үндсэн судалгаа: Морин хуур, хорчин цоор зэрэг хөгжмийн зэмсгүүдийн тухай судалгаа харьцангуй идэвхтэй хийгдсэн бол, цахар хийл, ойрад икил зэрэг бусад хөгжмийн зэмсгүүдийн судалгаа хангалтгүй байна.
- Бүс нутгийн судалгаа: Өвөр монгол, Хорчин, Алшаа зэрэг бүс нутгуудад түгээмэл хөгжмийн зэмсгүүдийн судалгаа хийгдсэн боловч бусад бүс нутгийн хувилбаруудыг харьцуулан судлах ажил дутуу байна.
- Хэрэглээний судалгаа: Хялгасан хуурын хөгжимдөлтийг орчин үеийн боловсрол, урлагийн салбарт хэрхэн нэвтрүүлэх талаарх судалгаа хомс байна.

Энэхүү судалгаа нь дээрх дутагдлыг арилгахын тулд хялгасан хууруудын бүх төрлийг нэгтгэн судлан, тэдгээрийн онцлог, уламжлал, орчин үеийн хэрэглээг нэг бүрчлэн шинжлэхэд чиглэсэн.

Судалгааны арга зүй

Эрдэм шинжилгээний өгүүлэл, ном зохиол зэрэг эх сурвалжаас өвөр монголын хялгасан хуурын тухай хөглөгөө дарлага, бүтэц, тоглох арга барил, хөгжмийн хэв маягтай холбогдох судалгааны үр дүнг шинжилж, судалгааны өнөөгийн чиг хандлага болон судлагдаагүй асуудлуудыг тодорхойлов. Судалгаанд дараах аргуудыг ашиглав.

- Ажиглалтын арга: Хөгжмийн соёлын орчинд шууд оролцож, хөгжмийн зэмсгийг урлах, тоглох үйл явцыг ажиглаж, уламжлалт арга барилыг бүртгэсэн),
- Ярилцлага: Хорчин цоор, цахар хийл, ойрад икил, морин хуур тоглодог хөгжимчид, хөгжмийн зэмсэг урлаачид, хөгжмийн судлаачидтай ярилцлага хийж, мэдээлэл цуглуулсан.
- Харьцуулалтын арга: Дээрх дөрвөн төрлийн хөгжмийн бүтэц, хөглөгөө, дарлагын арга барилыг харьцуулан ялгаатай болон ижил төстэй талыг тодорхойлов.

Судалгааны үр дүн

Хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсэг нь монголчуудын урт удаан жилийн нүүдэлчин амьдралаас үүсэн, оюун ухаан, өв соёл, бодол санаагаа шингээн туурвисан хөгжмийн зэмсэг юм. Эзэн Чингисийн ордноос эхлэн монгол гэрийн хананд хүртэл хялгасан хуурын дүрс тодордгийн учир монголчууд түүнийг Хаан хуур хэмээн үзэх нь бий. Дэлхийн өнцөг булан бүрд амьдран суурьшсан монголчууд гарал угсаа нэгтэй хэдий ч зан заншил нь харилцан адилгүй.

- Монгол Улсад хялгасан хуурыг ерөнхийдөө морин хуур, арьсан хуур гэх мэт томьёолдог.
- Өвөр монголд хялгасан хуурыг түүний уламжилж байгаа угсаатан, соёлын өвлөн уламжлагчаар дамжин морин хуур, хорчин цоор, цахар хийл, ойрад икил зэрэг хөгжмийн зэмсгийн олон төрлийн хөглөгөө, дарлагаар ялгадаг.
- Шинжаан Уйгар ба ОХУ-ын ТБНУ-д хялгасан хуурын төрлийн хөгжим нь ерөнхийдөө икил хуур юм.

Эрт дээр үеэс хялгасан хуур нь монголчуудын амьдралд байнга оршиж, нэгэн үндэстнийг төлөөлж буй соёл, урлагийн бэлгэдлийн зүйл болжээ. Мөн монгол угсаатан бүрийн хөгжлийг даган өөр өөрийн онцлогтой хөг татлагатай болж хөгжжээ. Хөгжим судлаач Д.Энхцэцэг “Хуурын татлага нь тогтвортой уламжлагдан, одоо ч хөгжмийн уран сайхны чухал хэрэглээ хэвээр байгаа нь хөгжимт соёлын уламжлал дахь аливаа үзэгдлийн тогтвортой шинж, амьдрах чадварыг хангаж байгаа хүчин зүйлүүдийн харилцан хамаарлын үр дүн мөн” (Энхцэцэг 2018, 50) гэсэн байдаг. Хялгасан хуурч Бүрэнбаяр “Монголчуудын дунд морин хуурыг эртнээс өнөөг хүртэл тус тусдаа нэрээр нэрлэдэг байсан. Жишээлбэл, алшаа, өөлд, торгуудын дунд хуучин заншил ёсоор морин хуурыг “икил” хэмээн нэрлэдэг. Шилийн гол аймгийн Цахар, Сүнэд, Үзэмчин нутгаар “хуржан хуур” (хүрз хэлбэртэй хуур) эсвэл “хийл хуур”, “хялгасан хуур” гэж нэрлэдэг. Хорчин, Харчинд “цоор” гэж нэлээд түгээмэл нэрлэдэг. Дархан хуурч Сун Лян ярихдаа, “Хорчин цоорын хуурч Сарааш багш амьд байхдаа манай Хорчин нутагт халбага хэлбэртэй цоор байсан гэж ярьдаг байсан” хэмээн дурссан. Зарим газар “арьсан хуур” буюу “арьс бүрсэн хуур” гэж нэрлэдэг. Хятад бичгийн эх сурвалжид “хулэй” буюу “хуур” эсвэл “шичин, жичин” гэж тэмдэглэсэн байдаг” (布林巴雅尔 2010 年第2期, 内蒙古艺术, 第124页). Хялгасан хуурын уламжлагдаж ирсэн олон төрлийн хөглөгөө, дарлагыг доор тайлбарлахыг оролдов.

Хүснэгт 1. Өвөр монголын хялгасан хуурын хөглөгөө дарлагын тодорхойлолт

Хөгжмийн зэмсэгийн нэр	Хөгийн нэр	Дарлагын нэр	Өвлөн уламжлагч
Морин хуур	Боржигин хөг	Буйллаг дарлага Түүвэр дарлага	Чи Булаг Бүрэнбаяр
Хорчин цоор	Цоор хөг	Хуур дарлага	Сэрааш, Бүрэнбаяр
Цахар хийл	Цахар хөг	Буйллаг дарлага	Балган, Бүрэнбаяр
Ойрад икил	Цоор хөг /Хийл хөг/	Торгууд дарлага /Ойрад дарлага/	Лү Бадмаа, Бүрэнбаяр



Зураг 1. Зүүнээс цахар хийл, хорчин цоор, морин хуур, ойрад икил

Нэг. Цоор хөгийн хуур дарлага. Цоор хөгийн хуур дарлага нь уулын Жирэм аймаг, Зуу Уд аймаг болон Хянган аймаг зэрэг хагас тариалан, хагас мал аж ахуйтай нутагт өргөн дэлгэрсэн уламжлалт хөгжимдөх арга болно. Хорчин нутгийн уугуул Сэрааш нь XX зууны цоор хөгийн хуур дарлагын гарамгай төлөөлөгч ба хүмүүс цоор хөгийн хуур дарлагыг бас Сэрааш хөгжимдөх арга буюу хорчины хөгжимдөх арга гэдэг. Цоор хөгийн онцлог нь нарийн чавхдас нь гадна талд нь байж, бүдүүн чавхдас нь дотор талд нь байршиж хоёр чавхдас нь цэвэр дөрөвцийн /кварт/ хөгтэй мөртөө зөв квартын хөгтэй. Хорчин цоор нь Мангасын үлгэрт хавсрал хөгжмийн зэмсэг байсан бол, одоо гоцлол хөгжмийн зэмсгийн хэлбэртэй хөгжиж байна. Ая аялгууны хувьд эртний Мангасын ая аялгууг хөгжимдөж аажмаар хорчин ардын богино дууны гоцлол хөгжим болон, Хорчин нутгийн тариалангийн соёлын уламжлагчийн дуу хөгжмийн хэв намбыг хадгалжээ. Цоор хөгийн хуур дарлага нь зүүн гарын долоовор хуруу, ядам хуруу, жижиг хуруу гэсэн гурван хурууны нэгдүгээр үеэр чавхдас дээр хөгжимддөг, ая аялгуу нь олон янзын зохицолтой байдаг болохоор бусад хөгжмийн зэмсгээс ялгагдах өвөрмөц хэв маягийг бүрдүүлдэг. Хорчин цоорын хуурч Сэрааш харьцангуй нам хөглөдөг тул түүний хөгжмийн дуугаралт нь нам бөгөөд өнгө ая нь зөөлөн байдаг. Тэрээр хорчин цоорын доод маарын хэсэгт монгол хутгыг налуулан суулгаснаар хуурын арьсны чичирхийллийг тохируулж, хөгжмийн дуугаралт өндөр шаардлагыг гүйцээжээ.

Хоёр. Цоор хөг /хийл хөг/-ийн торгууд дарлага /ойрад дарлага/. Цоор хөгийн торгууд дарлага нь одоогоор өвөр монголын зүүн хэсгийн Алшаа аймаг, ШУӨЗО, Монгол Улсын баруун аймагт өргөн тархсан байдаг. Алшаа аймагт тус дарлагыг ойрад дарлага, харин ШУӨЗО-д хийл хөгийн ойрад буюу хийл дарлага гэх мэт нэрлэж байна. Тус хөг нь дээр дурдсанчлан, хорчин цоорын хөгтэй адилхан цэвэр дөрөвц /кварт/ хөгтэй. “Жонон хар”, “Таван настай шарга” зэрэг нь ойрад дарлагын уламжлалт татлагатай. Алшаа нутагт Санжээ, Сүмбэр, Лү.Бадмаа зэрэг олон гарамгай хөгжимчид төрсөн байна.

Гурав. Цахар хөгийн буйллаг дарлага. Цахар хөгийн буйллаг дарлага нь одоогоор өвөр монголын Цахарт өргөн уламжлагдсан байна. Алшаа зүүн хошуу болон Энээ хошуудад ч бас энэхүү хөг уламжлагдаж иржээ. Алшаа аймагт мөн Өрөөлт хөг гэж нэрлэх нь бий. Цахар хөгийн нарийн чавхдас нь ля эгшигт, бүдүүн чавхдас нь ре эгшигт байж цэвэр тавцын /квинт/ хөгтэй мөртөө зөв квинтийн хөгтэй.

Хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсгүүд нь гарал нэгтэй ба хөгжлийн явцад өөрчлөгдсөн ч монгол үндэстний уламжлалт дуу хөгжмийн олон өвийг тээсээр ирсэн байна. Өвөр монголын хялгасан хуурын олон төрлийн хөглөгөө дарлагын дотор цахар хөгөөр хөглөдөг цахар хийл нь цахарын аж амьдралын нөлөөлөлд ордны хөгжмийн хэв намбатай болж, монгол үндэстний ордны найрал хөгжмийн /Асрын/ аялгууг хадгалснаас гадна найрал хөгжмийн гол хөгжмийн зэмсэг нь болсон байна. Цахар хөг нь цэвэр квинтийн учир уртын дуу хавсрахад зохицолтой бөгөөд өвөр монголын Шилийн гол аймгийн Авга хошуунд уламжлагдаж байгаа цоорын дууны цоорын хэсэгтэй адилхан ажээ. Энэ нь ч бас цахар хөгийн бусад хөгжмийн зэмсгээс ялгарах онцлог юм.

Дөрөв. Боржигин хөгийн буйллаг дарлага. Хялгасан хуурын өөр нэгэн төрөл болох морин хуур нь хамгийн түгээмэл хөгжиж, монголчуудын дархан хөгжмийн зэмсэг нь болжээ. Хөгжим судлаач Ж.Энэбиш морин хуурын тухай “Морин хуур гэдэг нь морь + хуур гэсэн хоёр үгнээс бүтжээ. Морин хуур нэрнээсээ авахуулаад түүний хийц бүтээц, технологийн бүх зүйл морьтой холбоотой. Ардын хөгжимчид гэрт хуур эгшиглэхэд уяан дээрх морьд үүрсдэг гэж ярилцдагийн цаад утга учир нь монгол хүн, морь, морин хуур (хөгжим) гурвын холбоо хамаарлыг тодруулж байна гэж ойлгож болно” (Энэбиш 2023, 112) гэжээ. Боржигин хөгийн хоёр чавхдас нь цэвэр дөрөвцийн /кварт/ хөгтэй боловч цоор хөгөөс өөр урвуу квартын хөгтэй байдаг. Эгшгийн хувьд морин хуурын бүдүүн чавхдас нь соль эгшигт, нарийн чавхдас нь до эгшигт байдаг. Харин Монголд нарийн чавхдасыг си бемоль эгшгээр, бүдүүн чавхдасыг фа эгшгээр хөглөдөг. Монголчууд тэмээний буйлахыг дуурайж морин хуурын хоёрдугаар атгалд исгэрэх дууг үүсгэдэг, энэ нь ч бас морин хуурын уламжлалт дарлагын нэгэн төрөл болно.

Тав. Боржигин хөгийн түүвэр дарлага. Боржигин хөгийн түүвэр дарлага гэдэг нь нэг (долоовор хуруу), хоёрдугаар (дунд хуруу) хурууны хумсны дээр үеэр хуурын чавхдасыг түлхэх хөгжимдөлтийг хэлнэ. Энэхүү дарлага нь морин хуурын түгээмэл дарлага ба зүүн гарын таван хурууны хөндлөнгийн талыг гүйцэд уялдуулсан байдгаараа онцлогтой. Түүвэр дарлага нь нягт, хурдан ноотуудыг тоглоход тод, нарийвчлалтай, дууны өнгийг цэвэр гаргаж чаддагаараа давуу талтай.

Өвөр монголын хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсгүүдийн хөглөгөө, дарлага, соёлын ач холбогдлыг судлан нэгтгэж үзвэл,

1. Хөглөгөө: Хялгасан хуур нь гурван төрлийн хөглөгөөтэй бөгөөд тус бүр өвөрмөц онцлогтой.
 - Цоор хөг (кварт)
 - Цахар хөг (квинт)
 - Боржигин хөг (урвуу кварт)

2. Дарлагын техник: Таван төрлийн дарлагын арга (хуур, торгууд, буйллаг, түүвэр, ойрад) бүр нь тухайн бүс нутгийн соёл, амьдралтай холбоотой өвөрмөц хэв маягтай.
3. Соёлын өв: Хөгжмийн зэмсэг бүр монголын түүх, нүүдэлчин амьдралыг тусгасан.
 - Хорчин цоор - баатарлаг туульс
 - Морин хуур - морьтой холбоотой
 - Цахар хийл - ордны хөгжим
 - Ойрад икил - говь нутгийн амьдрал
4. Хэрэглээний өнөөгийн байдал: Эдгээр хөгжмийн зэмсгүүд өнөө үед уламжлагдаж ирэхдээ зарим нь устаж, зарим нь өөрчлөгдсөн байна.

Хэлэлцүүлэг

Бид энэхүү судалгаандаа Өвөр монголын хялгасан хуурын тухай үе үеийн өв тээгчийн үлдээсэн бичлэгт тулгуурлан баримт сурвалж цуглуулан хялгасан хуурын олон төрлийн хөглөгөөний голлох хөгжимчидтэй ярилцан анхан шатны мэдээлэл цуглуулсан. Өвөр монголын хялгасан хуурыг судлахдаа дан ганц хөгжмийн зэмсэгт анхаарал хандуулах биш, харин хялгасан хуурыг багтаасан олон төрлийн хөглөгөө, хөгжмийн зэмсэг, дарлага зэргийг нийт монголчуудын өргөн их өв соёлын цар хүрээнд анхаарал хандуулан судлах хэрэгтэй.

Өвөр монголын хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсгийн тухай эрдэм шинжилгээний бүтээлүүд нь Өвөр монголд уламжлагдаж байгаа хялгасан хууруудыг судлан, шинжлэх ухааны үүднээс системчилсэн байгаа нь өвөр монголын хэмжээнд морин хуураас бусад хялгасан хуурын уламжлалын байдал дорой байсныг сэргээж, хялгасан хуурын дөрвөн зүйлийн хөгжмийн зэмсгийг хөгжүүлж, их сургуулийн сургалтын хөтөлбөрт орох түвшинд очсон байна. Мөн улс нийтээрээ өв соёлоо дээдлэн уламжлах ухамсар өндөр болж, хялгасан хуурын судалгаа олширч, сургалтын хүрээ өргөжин тэлсээр байна.

Дүгнэлт

Хялгасан хуурын төрлийн хөгжмийн зэмсэг нь эрт үеэс эхлэн монголчуудын уламжлалт хөгжмийн зэмсэг төдийгүй өвөрмөц онцлогтой, нүүдлийн соёлтой нягт уялдаатай, монгол морь, монгол хүн, монгол хөгжим гэх гурван талт харилцааг бүрдүүлжээ.

- Хорчин цоор нь эрт үеэс эхлэн баатарлаг туульст хавсрал хөгжмийн зэмсгийн хэлбэрээр өвлөгдөж хөгжсөн бөгөөд Хорчин нутгийн дуу хөгжмийн шинж чанартай.
- Морин хуур бол нүүдэлчдийн соёлын бүтээгдэхүүн, соёл урлагаа морьтой хослуулан илэрхийлдэгийн илэрхийлэл юм.
- Цахар хийлийг ордонд найрал хөгжмийн хэлбэрээр /Асар/ тоглож байсан ба найрал хөгжимд /Асар/ зориулсан хөг аялгууны нэрсийг бүхэлд нь цахар хийлийн хөг аялгууны нэршлээр тогтоодог байжээ. Иймээс цахар хийл нь ордны хөгжмийн хэв намбатай байдаг.

- Ойрад икил нь Алшаа нутагт өргөн уламжлагдаж торгууд дарлага, жонон дарлага зэрэг нэр нэршилтэй. Алшаа нутаг нь говь нутаг тул ойрад икилийн ихэнх урын сан нь тэмээ, адууны явдлыг илэрхийлдэг бөгөөд энэ нь тэдний ахуй амьдралтай нягт холбоотой байдаг.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Баянжаргал, Санжаажав. 2017. *Монгол хөгжимдүүрийн бүрэн бичиг*. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.

Жанцанноров, Нацаг. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Улаанбаатар: ШУА-ийн Информатикийн хүрээлэн.

Магсаржав. 1999. “*Морин хуур - хялгасны эзэрхигч*”. Улаанбаатар.

Наранхүү, Чойжилжав. 2019. *Монголын хөгжмийн түүх (нэн эртнээс XX зууны эхэн)*. Улаанбаатар.

Энэбиш, Жамбал. 2023. *Монгол үндэстний угсаатны хөгжмийн иж судлал*. Улаанбаатар.

Энхцэцэг, Данзан. 2018. *Хуурын татлага - Монголын хөгжимт соёлын феномен болох нь*. Улаанбаатар.

Хятад хэлээр:

Сандүүрэн, Алтансан. 1962. *Морин хуур ба түүний хөглөгөө дарлага татлагын тухайд*. Хөххот. 桑都仍、阿拉坦桑.1962年.《简述马头琴及其演奏法与定弦法》.内蒙古日报.

Бүрэнбаяр. 2010. *Хялгасан хуурын үүсэл хөгжил жич гурван зүйлийн хөглөгөө таван зүйлийн дарлага татлагын систем*. Хөххот. 布林巴雅尔.2010年.《简述马头琴及其定弦法与演奏法》.内蒙古艺术.